



АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГЫН  
БОЛОН СУМДЫН ДАРГА НАРТ

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗАР**

АЗДТГ-ын байр А корпус 1 давхар, 8 дугаар баг  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас: 7038 8849, 7038 8821, Факс: 7038 8848  
Цахим шуудан: khuvsgul-tender@khs.gov.mn  
Цахим хуудас: http://umch.khs.gov.mn

2022-12-26 № 1/972  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сургалт зохион байгуулах тухай**

Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох АЗ сертификатын сургалтыг 2023 оны 1 дүгээр сарын 14-ний өдрөөс 1 дүгээр сарын 18-ны өдрийн хооронд Мөрөн суманд зохион байгуулах тул сургалтад оролцох ирэн, төрийн албан хаагчийн мэдээллийг хавсралт хүснэгтээр гарган ирүүлнэ үү.


Сургалтын төлбөрийг урьдчилан төлсний дараа сургалтад оролцогчдыг бүртгэх тул сургалтын төлбөрийг сургалт зохион байгуулах мэргэжлийн байгууллагад 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрөөс өмнө төлсөн байх шаардлагатайг анхаарна уу.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэгт: "Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна" мөн хуулийн 47.6. дахь хэсэгт: "Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна", Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар баталсан "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын 2.3 дахь хэсэгт: "Үнэлгээний хороонд хоёроос доошгүй хөндлөнгийн гишүүн томилох ба нэн тэргүүнд салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын төлөөлөгчийг сонгоно", мөн журмын 2.4 дэх хэсэгт: "Орон нутаг дахь захиалагчийн зохион байгуулж буй тендер шалгаруулалтад төлөөлөл оролцуулах боломжтой салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, эсхүл төрийн бус байгууллага байхгүй бол аймаг, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас энэ журмын 2.7-д зааснаар хөтлөх жагсаалтад нэр орсон иргэнийг үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүнээр томилж болно" гэж тус тус заасан байх тул аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, иргэдийн төлөөлөгчдийн хурал, төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд төрийн албан хаагч бус иргэнийг худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтад хамруулж АЗ сертификаттай болгох талаар дорвитой арга хэмжээ авч иргэдийг АЗ сертификаттай болгох хэрэгтэй байна.

Түүнчлэн төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт бэлтгэх, хүлээн авах, санхүүжилт олгох, үнэлгээний хороонд ажиллах зэрэг чиг үүрэг бүхий төрийн албан хаагч, ажилтнуудыг худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтад хамруулж, АЗ сертификаттай болгох талаар аймгийн Засаг даргын 2022 оны 1/2645 дугаар албан бичгээр хүргүүлсэн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж ажиллахыг сум, агентлаг, байгууллагын дарга нарт даалгаж байна.

Сургалттай холбоотой мэдээллийг 70388821, 70383809 дугаарын утаснаас авах боломжтой.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ДОЖИНСОРОГДОГ



d/A4

67120-1002



Аймгийн Орон нутгийн өмчийн газрын  
2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн  
1/972 дугаар албан бичгийн хавсралт

**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ СУУРЬ МЭДЛЭГ ОЛГОХ  
А3 СЕРТИФИКАТЫН СУРГАЛТАД ХАМРАГДАХ ИРГЭДИЙН СУДАЛГАА АВАХ**

№	Овог нэр	Регистрийн дугаар	Мэргэжил, боловсрол	Байгууллагын нэр	Эрхэлсэн ажил, албан тушаал	Мэйл хаяг	Утасны дугаар
1							
2							

СУДАЛГАА ГАРГАСАН: